



ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2017 оны 08 дугаар
сарын 31-ний өдөр

Дугаар А/168

Улаанбаатар
хот

Жагсаалт батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.2, 8.4, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 163 дугаар зүйлийн 163.1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийтэд тустай ажил хийлгэх ялаар шийтгүүлсэн ялтныг ажиллуулах байгууллагын жагсаалт хавсралтаар баталсугай.

2. Жагсаалтаар батлагдсан байгууллагад ялтны ялыг эдлүүлэх ажлыг зохион байгуулж, энэ тушаалыг 2017 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхийг Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх алба /хурандаа Х.Ариунболд/-д даалгасугай

ДАРГА, БРИГАДЫН ГЕНЕРАЛ

Ц.АМГАЛАНБАЯР

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх
ерөнхий газрын даргын 2017 оны
08 дугаар сарын 31-ний өдрийн
А/168 дугаар тушаалын хавсралт

НИЙТЭД ТУСТАЙ АЖИЛ ХИЙЛГЭХ ЯЛААР ШИЙТГҮҮЛСЭН ЯЛТНЫГ АЖИЛЛУУЛАХ БАЙГУУЛЛАГЫН ЖАГСААЛТ

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай Монгол улсын хуулийн 163 дугаар зүйлийн 163.1 дэх хэсэгт зааснаар нийтэд тустай ажил хийлгэх ялаар шийтгүүлсэн ялтнуудыг дараах байгууллагуудад ажиллуулна. Үүнд:

1. Аймаг, нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд:

1. Авто замын хөгжлийн газар;
2. Агаарын бохирдлыг бохирдуулах газар;
3. Архивын газар;
4. Аялал жуулчлалын газар;
5. Байгаль орчны газар;
6. Нийтийн биеийн тамир, спортын хороо;
7. Боловсролын газар;
8. Нийслэлийн Газрын алба;
9. Нийслэлийн хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газар;
10. Гэр хорооллын дэд бүтцийн газар;
11. Дотоод аудитын алба;
12. Залуучуудын хөгжлийн газар;
13. Мал эмнэлэгийн газар;
14. Мэдээллийн технологийн газар;
15. Мэргэжлийн хяналтын газар;
16. Нийгмийн даатгалын газар;
17. Нийгмийн халамжийн газар;
18. Нийтлэг үйлчилгээний газар;
19. Нийслэлийн бүртгэлийн газар;
20. Онцгой байдлын газар (Нөөцийн албатай);
21. Өмчийн харилцааны газар;
22. Статистикийн газар;
23. Соёл, урлагийн газар;
24. Татварын газар;
25. Тээврийн газар;
26. Хөдөлмөр эрхлэлтийн газар;
27. Хүнс, хөдөө аж ахуйн газар;
28. Худалдан авах ажиллагааны газар;
29. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газар;
30. Улаанбаатар хотын цагдаагийн газар;
31. Үйлдвэрлэл, инновацийн газар;
32. Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн алба;
33. Эрүүл мэндийн газар.

2.Сум, дүүргийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд:

- 1.Боловсролын хэлтэс;
- 2.Биеийн тамир, спортын хороо;
- 3.Газрын алба;
- 4.Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс;
- 5.Дотоодын аудитын алба;
- 6.Замын цагдаагийн хэлтэс;
- 7.Мэргэжлийн хяналтын хэлтэс;
- 8.Онцгой байдлын хэлтэс;
- 9.Статистикийн хэлтэс;
- 10.Соёлын ордон;
- 11.Татварын хэлтэс;
- 12.Улсын бүртгэлийн хэлтэс;
- 13.Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэс;
- 14.Худалдан авах ажиллагааны алба;
- 15.Цагдаагийн хэлтэс;
- 16.Эрүүл мэндийн даатгалын хэлтэс;
- 17.Эрүүл мэндийн нэгдэл.

3.Аймаг нийслэл, сум дүүргийн төрийн өмчит үйлдвэрийн газар, орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газруудад тус тус эдлүүлнэ.

---oo0oo---